

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 02-р сарын 15-ны өдөр

№ 2202/01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46.1, 46.6, 47.1 болон компанийн дүрмийн 7.32.10-р заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахаар стратегийн томоохон ажиллуудыг хийж байгаа ч эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан 2021 онд алдагдалтай ажилласан учраас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн болохыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нийт хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг ТУЗ-ийн дарга /Б.Насан-Эрдэнэ/-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх, компанийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх арга хэмжээ авахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ж.Үүрийнтуяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА *Насан-Эрдэнэ* Б.НАСАН-ЭРДЭНЭ

